

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ- 2026/227/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас:261885 Цахим хаяг: chantsaldulam.p@audit.gov.mn
Аудитор: Г.Тэлмүүн
Утас:261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	22
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	24
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Төлбөрийн акт	25
5.2 Албан шаардлага	26
5.3 Зөвлөмж	27
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮФӨ	Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/357

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 725,049.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1,561,861.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2,980,409.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,247,011.7 мянган төгрөг буюу 86.0 хувьтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын их хурлын 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл"-д "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас

бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ” гэж тусгасны дагуу цомхотгол хийгээгүй байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  ЦНАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,153,121,504.26	937,365,072.46
31	Мөнгөн хөрөнгө	3,401,511.52	24,027,453.41
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,401,511.52	23,509,303.41
31210	Төгрөг	3,401,511.52	23,509,303.41
31211	Төрийн сангийн харилцах	3,401,511.52	23,509,303.41
31400	Замд яваа мөнгө	-	518,150.00
33	АВЛАГА	468,859,526.08	282,183,588.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	228,427,049.33	12,436,021.60
33300	Татаас, санхүүжилтийн авлага	85,000,000.00	49,442,807.00
335	Бусад авлага	154,875,068.90	220,304,760.00
3351	Байгууллагаас авах авлага	154,875,068.90	220,304,760.00
3351011	Эм худалдсаны авлага	-	220,291,930.00
3351014	Бусад зардлын тооцооны авлага	-	12,830.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	557,407.85	-
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	-	2,004,334.00
34700	Бусад урьдчилгаа	-	2,004,334.00
34710	Урьдчилгаа тооцоо	-	2,004,334.00
34713	Цалингийн урьдчилгаа	-	2,004,334.00
35	БАРАА МАТЕРИАЛ	680,860,466.66	629,149,696.45
351	Түүхий эд материал	407,646,132.21	287,247,812.12
3511	Тусгай зориулалттай материал	214,333,631.59	233,835,218.52
3513	Эм боох материал	92,800,982.66	53,412,593.60
3520	Дуусаагүй үйлдвэрлэл	9,671,244.52	53,774.00
3530	Бэлэн бүтээгдэхүүн	90,840,273.44	107,683,282.75
3540	Хангамжийн материал	270,490,404.45	229,887,810.58
3541	Бичиг хэргийн материал	155,546,429.00	14,507,211.00
3542	Аж ахуйн материал	21,713,715.80	23,907,129.00
3543	Сэлбэг хэрэгсэл	3,920,000.00	3,990,000.00
3544	Түлш, шатах тослох материал	993,748.65	561,682.58
3545	Барилгын засварын материал	27,411,050.00	14,959,700.00
3546	Хүнсний материал	3,430,470.00	1,466,623.00
3547	Бусад хангамжийн материал	57,474,991.00	170,495,465.00
3560	Мал амьтад	2,723,930.00	4,277,017.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,053,016,738.28	3,130,621,555.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,053,016,738.28	3,130,621,555.01
392	Биет хөрөнгө	2,459,494,218.72	2,537,910,702.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,725,630,341.98	1,734,130,341.98
39202	Хуримтлагдсан элэгдэл	(348,348,254.02)	(386,884,516.27)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	61,411,200.00	50,385,480.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,968,525.00)	(10,268,350.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,774,794,708.00	1,794,570,987.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(872,405,512.87)	(863,458,322.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	295,736,671.00	326,200,176.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(152,218,962.37)	(117,627,646.18)
39217	Номын фонд	10,862,552.00	10,862,552.00
393	Биет бус хөрөнгө	593,522,519.56	592,710,852.69
39301	Программ хангамж	4,400,000.00	4,340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,933,333.29)	(4,125,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	594,782,520.00	594,782,520.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,726,667.15)	(2,286,667.31)

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	4,206,138,242.54	4,067,986,627.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	387,495,298.25	534,262,859.23
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	387,495,298.25	534,262,859.23
413	Өглөг	387,495,298.25	534,262,859.23
41310	Ажиллагчидтай холбогдсон өглөг	259,248,412.25	298,989,064.43
41312	НДШ-ийн өглөг	135,270,841.60	205,977,859.34
41313	ХАОАТ-ын өглөг	123,976,670.65	90,496,491.09
41314	ҮЭ-ийн өглөг	900.00	2,514,714.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	81,295,302.20	134,444,356.00
413207	Албан томилолтын өглөг	-	1,471,620.00
413208	Хоолны өглөг	-	10,657,705.00
413209	Эмийн өглөг	-	117,515,031.00
413210	Урсгал засварын зардлын өглөг	-	4,800,000.00
413213	Бусад зардлын өглөг	81,295,302.20	-
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	36,500,000.00	75,566,000.00
4136	Бусад өглөг	10,451,583.80	25,263,438.80
41361	Байгууллагад төлөх өглөг	9,799,201.80	22,483,501.80
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	652,382.00	2,779,937.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	3,818,642,944.29	3,533,723,768.24
51	Засгийн газрын хувь оролцоо	3,818,642,944.29	3,533,723,768.24
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ -төрийн	2,875,411,193.51	2,875,411,193.51
51101	Өмч: - төрийн	2,875,411,193.51	2,875,411,193.51
512	Хуримтлагдсан үр дүн	573,674,760.16	288,755,584.11
5121	Өмнөх үеийн үр дүн	583,730,872.36	573,674,760.16
5122	Тайлант үеийн үр дүн	(10,056,112.20)	(284,919,176.05)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	369,556,990.62	369,556,990.62
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	4,206,138,242.54	4,067,986,627.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,386,515,283.06	4,589,219,016.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,088,132,796.32	1,901,372,148.65
120	Нийтлэг татварын бус орлого	1,088,132,796.32	1,901,372,148.65
120004	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	1,088,132,796.32	1,901,372,148.65
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	257,036,470.52	629,225,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	813,932,915.00	932,596,780.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	326,083,539.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	17,163,410.80	13,466,669.65
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,870,173,872.74	1,824,800,835.00
1310	Улсын төсвөөс	824,509,500.00	725,083,435.00
131001	Урсгал	824,509,500.00	725,083,435.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,045,664,372.74	1,099,717,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,095,400.00	106,737,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	745,568,972.74	992,980,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,428,208,614.00	2,764,418,181.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,428,208,614.00	2,764,418,181.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	6,353,466,048.70	6,775,510,340.70
21	Урсгал зардал	6,353,466,048.70	6,775,510,340.70
210	Бараа, үйлчилгээний зардал	6,268,731,197.27	6,613,867,423.23
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,752,775,534.15	3,978,077,857.00
210101	Үндсэн цалин	2,648,016,841.15	2,941,642,518.00
210102	Нэмэгдэл	786,678,778.00	739,317,665.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	113,321,660.00	138,283,151.00
210104	Урамшуулал	168,581,216.00	114,334,255.00
210105	Гэрээт ажлын хөлс	36,177,039.00	44,500,268.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	470,722,799.39	500,947,903.57
210201	Тэтгэврийн даатгал	356,426,711.83	395,726,801.33
210202	Тэтгэмжийн даатгал	30,752,144.12	25,533,107.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	19,943,360.25	20,868,406.48
210204	Ажилгүйдлийн даатгал	11,083,753.25	12,901,956.96
210205	Эрүүл мэндийн даатгал	52,516,829.95	45,917,631.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	199,808,655.97	211,170,689.57
210301	Гэрэл, цахилгаан	70,382,839.95	92,487,835.20
210302	Түлш, халаалт	63,976,785.90	62,134,613.82
210303	Цэвэр, бохир ус	65,449,030.12	56,548,240.55
2104	Хангамж, бараа материалын зардал	175,009,524.96	204,239,123.27
210401	Бичиг хэрэг	32,026,630.00	13,315,800.00
210402	Тээвэр, шатахуун	4,863,434.00	4,340,665.71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,635,814.86	9,726,275.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	52,888,105.60	53,557,167.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	75,355,540.50	82,752,712.80
210408	Бараа материал актласны зардал	-	40,546,502.76
210409	Бараа материал шилжүүлсэний зардал	240,000.00	-

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	711,006,700.57	715,758,587.88
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	332,172,025.57	327,197,975.38
210502	Хоол, хүнс	378,834,675.00	388,560,612.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	298,737,796.00	140,158,590.00
210604	Урсгал засвар	298,737,796.00	140,158,590.00
2107	Томилолт, зочны зардал	49,714,634.80	51,441,120.00
210701	Гадаад албан томилолт	18,499,200.00	19,556,120.00
210702	Дотоод албан томилолт	31,215,434.80	26,385,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	5,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	196,929,248.24	237,386,401.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	183,009,217.24	224,021,151.47
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,589,200.00	6,410,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,500.00	713,840.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,956.00	708,768.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,349,160.00	-
210807	Газрын төлбөр	3,469,875.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,099,340.00	1,492,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	414,026,303.19	574,687,150.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,471,509.04	181,600,868.20
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	6,216,000.00	2,611,560.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	374,338,794.15	390,474,722.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,734,851.43	161,642,917.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,354,911.00	159,524,655.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп	53,411,061.00	155,120,905.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,943,850.00	4,403,750.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,379,940.43	2,118,262.47
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	15,316,473.43	2,084,048.54
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	63,467.00	34,213.93
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(33,049,234.35)	(284,919,176.05)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	43,105,346.55	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	11,920,194.35	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал	31,185,152.20	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	(43,105,346.55)	-
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(10,056,112.20)	(284,919,176.05)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,358,698,651.28	6,377,599,903.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,071,130,283.61	1,561,887,470.85
120	Нийтлэг татварын бус орлого	1,071,130,283.61	1,561,887,470.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,071,130,283.61	1,561,887,470.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	257,092,352.00	629,225,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	814,037,931.61	932,641,903.85
120009	Бусад орлого	-	20,407.00
1310	Улсын төсвөөс	824,509,500.00	725,083,435.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	824,509,500.00	725,083,435.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,259,532,278.00	1,110,219,789.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	397,040,209.00	191,737,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	862,492,069.00	918,482,389.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,203,526,589.67	2,980,409,208.73
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,203,526,589.67	2,980,409,208.73
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,203,526,589.67	2,980,409,208.73
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	1,071,130,283.61	1,561,887,470.85
1200	Нийтлэг татварын бус орлого	1,071,130,283.61	1,561,887,470.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,071,130,283.61	1,561,887,470.85
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	257,092,352.00	629,225,160.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	814,037,931.61	932,641,903.85
120009	Бусад орлого	-	20,407.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	5,989,833,380.03	6,281,053,961.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,989,833,380.03	6,281,053,961.69
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,820,593,956.60	6,073,809,487.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	3,667,445,553.50	3,965,747,214.25
210101	Үндсэн цалин	2,565,773,307.50	2,931,482,126.25
210102	Нэмэгдэл	786,678,778.00	739,317,665.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	113,321,660.00	138,283,151.00
210104	Урамшуулал	168,581,216.00	114,334,255.00
210105	Гэрээт ажлын хөлс	33,090,592.00	42,330,017.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	413,263,503.43	477,369,756.14
210201	Тэтгэврийн даатгал	322,215,489.86	372,148,653.90
210202	Тэтгэмжийн даатгал	24,131,122.43	25,533,107.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,619,775.08	20,868,406.48
210204	Ажилгүйдлийн даатгал	9,725,546.51	12,901,956.96
210205	Эрүүл мэндийн даатгал	42,571,569.55	45,917,631.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	214,089,149.37	211,170,689.57
210301	Гэрэл, цахилгаан	73,344,182.95	92,487,835.20
210302	Түлш, халаалт	73,262,291.13	62,134,613.82
210303	Цэвэр, бохир ус	67,482,675.29	56,548,240.55
2104	Хангамж, бараа материалын зардал	178,535,300.06	152,693,865.00
210401	Бичиг хэрэг	13,625,828.00	11,304,150.00
210402	Тээвэр, шатахуун	3,762,600.00	3,731,830.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,635,814.86	9,726,275.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	53,163,640.00	53,551,090.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	98,347,417.20	74,380,520.00

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2105	Нормативт зардал	799,412,986.00	798,290,533.60
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	412,494,886.00	402,650,273.10
210502	Хоол, хүнс	384,222,300.00	367,919,060.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,695,800.00	27,721,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,883,107.00	169,341,932.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	30,290,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,710,000.00	5,329,500.00
210604	Урсгал засвар	258,173,107.00	133,722,432.20
2107	Томилолт, зочны зардал	50,321,300.00	49,969,500.00
210701	Гадаад албан томилолт	18,499,200.00	18,084,500.00
210702	Дотоод албан томилолт	31,822,100.00	26,385,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	5,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	207,879,547.24	228,851,121.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	192,946,616.24	219,389,171.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,589,200.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	202,500.00	713,840.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	209,956.00	708,768.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	4,000,000.00	-
210807	Газрын төлбөр	3,469,875.00	4,039,342.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,461,400.00	1,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,763,510.00	20,374,875.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,246,690.00	16,817,475.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	9,516,820.00	3,557,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	169,239,423.43	207,244,474.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	68,859,483.00	155,683,405.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	53,411,061.00	155,120,905.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,448,422.00	562,500.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,379,940.43	51,561,069.47
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100,316,473.43	51,526,855.54
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	63,467.00	34,213.93
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	368,865,271.25	96,545,941.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	372,429,963.00	75,920,000.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	372,429,963.00	75,920,000.00
2251	Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	372,429,963.00	75,920,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	372,429,963.00	75,920,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(372,429,963.00)	(75,920,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	(3,565,055.75)	20,625,941.89
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,966,567.27	3,401,511.52
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,401,511.52	24,027,453.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	537,466,700.62	415,799,498.26	3,828,677,392.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	167,931,374.10	167,931,374.10
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(167,909,710.00)	-	(167,909,710.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	(10,056,112.20)	(10,056,112.20)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	369,556,990.62	573,674,760.16	3,818,642,944.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(284,919,176.05)	(284,919,176.05)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,875,411,193.51	369,556,990.62	288,755,584.11	3,533,723,768.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,098,033,800.00	5,267,325,493.65	830,708,306.35	86.4
12	Татварын бус орлого	5,332,302,800.00	4,542,276,272.58	790,026,527.42	85.2
122	Тусламжийн орлого	5,332,302,800.00	4,542,276,272.58	790,026,527.42	85.2
122005	Төсвөөс санхүүжих	5,332,302,800.00	4,542,276,272.58	790,026,527.42	85.2
122001	Хандив тусламж /дотоод/	3,513,331,900.00	2,980,409,208.73	532,922,691.27	84.8
120041	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого /үндсэн/	820,301,000.00	629,225,160.00	191,075,840.00	76.7
120042	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого /туслах/	998,669,900.00	932,641,903.85	66,027,996.15	93.4
	Татаас, санхүүжилтийн орлого	765,731,000.00	725,049,221.07	40,681,778.93	94.7
131	Улсын төсвөөс	765,731,000.00	725,049,221.07	40,681,778.93	94.7
131001	Урсгал	765,731,000.00	725,049,221.07	40,681,778.93	94.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,098,033,800.00	5,247,011,701.76	851,022,098.24	86.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,098,033,800.00	5,247,011,701.76	851,022,098.24	86.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,919,995,200.00	5,091,328,296.76	828,666,903.24	86.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,998,200,500.00	3,515,284,744.25	482,915,755.75	87.9
210101	Үндсэн цалин	2,851,124,300.00	2,587,239,667.25	263,884,632.75	90.7
210102	Нэмэгдэл	598,658,300.00	687,293,321.00	(88,635,021.00)	114.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	261,028,500.00	126,417,501.00	134,610,999.00	48.4
210104	Урамшуулал	287,389,400.00	114,334,255.00	173,055,145.00	39.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	574,859,300.00	419,276,004.14	155,583,295.86	72.9
210201	Тэтгэврийн даатгал	443,624,100.00	333,097,968.10	110,526,131.90	75.1
210202	Тэтгэмжийн даатгал	32,308,300.00	20,949,473.91	11,358,826.09	64.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,250,100.00	17,035,344.54	1,214,755.46	93.3
210204	Ажилгүйдлийн даатгал	16,135,400.00	10,608,140.26	5,527,259.74	65.7
210205	Эрүүл мэндийн даатгал	64,541,400.00	37,585,077.33	26,956,322.67	58.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	221,250,300.00	205,445,449.57	15,804,850.43	92.9
210301	Гэрэл, цахилгаан	72,031,100.00	86,762,595.20	(14,731,495.20)	120.5
210302	Түлш, халаалт	80,337,600.00	62,134,613.82	18,202,986.18	77.3
210303	Цэвэр, бохир ус	68,881,600.00	56,548,240.55	12,333,359.45	82.1
2104	Хангамж, бараа материалын зардал	139,633,900.00	112,843,365.00	26,790,535.00	80.8
210401	Бичиг хэрэг	7,666,300.00	7,911,650.00	(245,350.00)	103.2
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	239,830.00	760,170.00	24.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,585,700.00	9,726,275.00	2,859,425.00	77.3
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	54,654,400.00	53,551,090.00	1,103,310.00	98.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,727,500.00	41,414,520.00	22,312,980.00	65.0
2105	Нормативт зардал	641,073,800.00	535,666,023.60	105,407,776.40	83.6

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	371,573,700.00	247,343,763.10	124,229,936.90	66.6
210502	Хоол, хүнс	250,000,000.00	266,705,060.50	(16,705,060.50)	106.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	19,500,100.00	21,617,200.00	(2,117,100.00)	110.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	183,175,500.00	154,006,962.20	29,168,537.80	84.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,490,000.00	40,910,000.00	18,580,000.00	68.8
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,496,800.00	1,834,500.00	2,662,300.00	40.8
210604	Урсгал засвар	119,188,700.00	111,262,462.20	7,926,237.80	93.3
2107	Томилолт, зочны зардал	1,680,000.00	1,680,000.00	-	100.0
210701	Дотоод албан томилолт	1,680,000.00	1,680,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	136,893,800.00	126,750,873.00	10,142,927.00	92.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	124,647,200.00	118,022,975.00	6,624,225.00	94.7
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,739,700.00	2,500,000.00	2,239,700.00	52.7
210803	Даатгалын үйлчилгээ	202,500.00	202,500.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	495,900.00	486,056.00	9,844.00	98.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	119,500.00	-	119,500.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,119,900.00	-	1,119,900.00	0.0
210807	Газрын төлбөр	4,069,100.00	4,039,342.00	29,758.00	99.3
210808	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,228,100.00	20,374,875.00	2,853,225.00	87.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,633,700.00	16,817,475.00	2,816,225.00	85.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,594,400.00	3,557,400.00	37,000.00	99.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	178,038,600.00	155,683,405.00	22,355,195.00	87.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	178,038,600.00	155,683,405.00	22,355,195.00	87.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	172,038,600.00	155,120,905.00	16,917,695.00	90.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.00	562,500.00	5,437,500.00	9.4
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	23,715,303.41	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	149	120	29	80.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	149	120	29	80.5
620001	Удирдах ажилтан	21	18	3	85.7
620002	Гүйцэтгэх ажилтан	96	74	22	77.1
620003	Үйлчлэх ажилтан	32	28	4	87.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,110,240,196.00
12	Татварын бус орлого	20,407.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,407.00
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	20,407.00
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,110,219,789.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,110,219,789.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	191,737,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	918,482,389.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	1,109,928,046.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,109,928,046.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,058,401,190.46
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	450,462,470.00
210101	Үндсэн цалин	344,242,459.00
210102	Нэмэгдэл	52,024,344.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	11,865,650.00
210105	Гэрээт ажлын цалин	42,330,017.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,093,752.00
210201	Тэтгэврийн даатгал	39,050,685.80
210202	Тэтгэмжийн даатгал	4,583,633.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,833,061.94
210204	Ажилгүйдлийн даатгал	2,293,816.70
210205	Эрүүл мэндийн даатгал	8,332,554.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,725,240.00
210301	Гэрэл, цахилгаан	5,725,240.00
2104	Хангамж, бараа материалын зардал	39,850,500.00
210401	Бичиг хэрэг	3,392,500.00
210402	Тээвэр, шатахуун	3,492,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,966,000.00
2105	Нормативт зардал	262,624,510.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	155,306,510.00
210502	Хоол, хүнс	101,214,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,104,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91,254,970.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	56,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,495,000.00
210604	Урсгал засвар	30,959,970.00
2107	Томилолт, зочны зардал	48,289,500.00
210701	Гадаад албан томилолт	18,084,500.00
210702	Дотоод албан томилолт	24,705,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,100,248.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,366,196.46
210803	Даатгалын үйлчилгээ	511,340.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	222,712.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,526,855.54
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,526,855.54
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	51,526,855.54
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	1,109,928,046.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	312,150.00
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	312,150.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн газрын 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолоор Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн болж өөрчлөгдөн, улмаар Монгол улсын боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2024 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн А/132 дугаар тушаалаар дүрэм, зохион байгуулалтаа батлуулан, эрдэм шинжилгээ, сургалт, эмчилгээ, эм үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Тус хүрээлэнгийн эрхэм зорилго нь Монголын уламжлалт анагаах ухааны мэдлэг, туршлага, оюуны баялаг өв санг орчин үеийн судалгаа шинжилгээний аргуудаар нотолгоожуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэхэд оршино.

Хүрээлэн нь эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Стратегийн зорилт 1: Уламжлалт анагаах ухаан судлалын судалгаа боловсруулалтын ажлыг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, нийгэм эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Стратегийн зорилт 2: Хүний нөөцийг чадавхижуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлж, түүхий эд материалын хангамжийг сайжруулах байгалийн гаралтай эмчилгээний өндөр идэвхитэй гаж нөлөөгүй стандартын шаардлага хангасан уламжлалт эм үйлдвэрлэх;
- Стратегийн зорилт 3: Уламжлалт анагаах ухааны төрөлжсөн тусламж үйлчилгээг бэхжүүлэх юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус хүрээлэн үйл ажиллагаандаа Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Патетын тухай, Инновацийн тухай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг мөрдлөг болгон хэрэгжүүлдэг байна.

Тайлант хугацаанд Хүрээлэнгийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал,

- Эрүүл мэндийн даатгалын сангийн тухай хууль;
- Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт орсон;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Сангийн сайдын 2025 оны А/03 тоот тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам.

Тус хүрээлэнгийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уламжлалт анагаах ухаан, Технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Уламжлалт анагаах Ухаан, Технологийн хүрээлэн нь Боловсрол Шинжлэх Ухааны Яамнаас бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон үйл ажиллагаандаа ашигладаг.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй, үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Хүрээлэн нь 2024 онд Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болсон тул салбарын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөх шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,151.6 мянган төгрөгөөр буюу 3.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,401.5	24,027.4	20,625.9
Авлага	468,859.5	282,183.6	(186,675.9)
Урьдчилгаа	-	2,004.3	2,004.3
Бараа материал	680,860.5	629,149.7	(51,710.8)
Үндсэн хөрөнгө	3,053,016.7	3,130,621.6	77,604.9
Нийт хөрөнгө	4,206,138.2	4,067,986.6	(138,151.6)
Өр төлбөр	387,495.3	534,262.8	146,767.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,818,642.9	3,533,723.8	(284,919.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,206,138.2	4,067,986.6	(138,151.6)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 20,625.9 мянган төгрөгөөр өссөн нь суралцагчдын төлбөр болох 14,044.8 мянган төгрөг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр дансанд орсон мөн эмчлүүлэгчдийн төлбөрийн орлого 8,545.1 мянган төгрөг төвлөрсөнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 186,675.9 мянган төгрөгөөр буурсан нь эмийн борлуулалтын авлага 73,748.0 мянган төгрөгөөр өссөн боловч эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн авлага 215,991.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн авлага 35,557.2 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан

Бараа материал дансны үлдэгдэл 51,710.8 мянган төгрөгөөр буурсан нь эмийн борлуулалт өссөнтэй холбоотойгоор дуусаагүй үйлдвэрлэл, эм боох материал болон бусад материалын данс буурснаас голлон шалтгаалсан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 77,604.9 мянган төгрөгөөр өссөн нь 141,996.0 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авч, төслийн хүрээнд хандиваар ирсэн 31,785.7 мянган төгрөгийн бага оврын трактор хүлээн авсантай холбоотой. Мөн 420,425.4 мянган төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацаа болон үнийг 294,297.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон

Биет бус хөрөнгөд Хас эрин орчил ХХК-ийн “Dynamic 1.0” санхүүгийн программ 1,200.0 мянган төгрөг, И Эй Эс Ти ХХК-ийн кассын програм 150.0 мянган төгрөг, санхүүгийн тооцолохын үндсэн хөрөнгийн 3,000.0 мянган төгрөг, Аксис систем ХХК-ийн Health.gov.mn даатгалын програм гэсэн 4 програм бүртгэлтэй байна. Тус програмуудын ашиглалтын зардалд жилд 14,430.0 мянган төгрөг төлж байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 146,767.5 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн тодотгол хийгдсэн мөн нэмэлт санхүүжилтийн эрхийг 10 дугаар сараас хойш нээж өгөөгүйтэй холбоотой албан хаагчидтай холбоотой НДШ, ХХОАТ-ийн өглөг болон ҮЭ-ийн өглөг 39,740.7 мянган төгрөг, бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх 107,026.8 мянган төгрөгийн өглөгийг бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо данс тайлант үеийн үр дүн 284,919.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,016,886.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 4,767,620.5 мянган төгрөг, нийт 5,784,507.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 682,403.3 мянган төгрөгөөр бууруулж, 5,102,103.9 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 871,895.9 мянган төгрөгөөр дадлагжигч эмч нарын цалин, эм, эмнэлгийн хэрэгслэлийн санхүүжилтийг нэмэгдүүлэн тодотгож 5,973,999.8 мянган төгрөгөөр баталсан байна. Оны эцэст батлагдсан төсвийг дадлагжигч эмч нарын цалингийн санхүүжилт 121,534.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 6,095,533.8 мянган төгрөгөөр төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 765,731.0 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,513,331.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,816,470.9 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төсөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 725,049.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 1,561,867.1 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 2,980,409.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,247,011.7 мянган төгрөг буюу 86.0 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 757,556.8 мянган төгрөг, ажил олгогчоос олгох шагнал урамшууллын зардлыг 20,407.1 мянган төгрөгөөр, дээд шатны төсвөөс хуваарилсан төсвөөс зарцуулах цалин хөлс, НДШ-ийн зардлыг 70,558.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	71805-Шинжлэх ухаан, технологи	765,731.0	725,049.1	40,681.9	94.7
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	667,157.1	641,444.9	25,712.2	96.1
1.2	80219- Харуул хамгаалалт	64,647.2	64,647.2	-	100.0
1.3	80802-Ажил олгогчоос олгох шагнал урамшуулал	33,926.7	18,957.0	14,969.7	55.9
2	71601-Нийгмийн эрүүл мэнд	5,329,802.8	4,521,962.5	807,840.3	84.8
2.1	80101-Үндсэн үйл ажиллагаа	4,118,245.9	3,386,401.3	731,844.6	82.2
2.2	80802-Ажил олгогчоос олгох шагнал урамшуулал	6,000.0	562.5	5,437.5	9.4
2.3	83603-Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан	1,205,556.9	1,134,998.7	70,558.2	94.1

1. Тус байгууллага нь орон тооны цомхотголыг хэрэгжүүлж ажиллаагүй бөгөөд 2025 оны А/01 тушаалаар 150 орон тоо батлагдсан. сул орон тоон дээр хүн аваагүй ба гүйцэтгэлээр 120 ажилтан ажилласан байна.
2. Хоол унааны хөнгөлөлтийг олгохдоо Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг 6.0 мянган төгрөгөөр тооцон олгож байна. Тайлант оны батлагдсан төсөв 261,028.5 мянган төгрөг, гүйцэтгэлээр 126,417.5 мянган төгрөг буюу 134,611.0 мянган төгрөгийн хэмнэлттэй.
3. Тайлант онд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хүрээнд эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлаас 19,584.5 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал болон 4,000.0 мянган төгрөгийн зочид хүлээн авах зардал тус тус гарсан байна. Тайвань болон БНХАУ-тай хамтарсан төслүүдийн үр дүнд олон улсын сэтгүүлд 5 илтгэл өгүүлэл хэвлүүлж, хэлэлцүүлсэн ба 1 илтгэл олон улсын хуралд тавьж, судалгааны ажлаа олон улсад түгээн дэлгэрүүлсэн. Захиалгат төслийн хүрээнд нийт судалгааны 350 зургийн оношлогоог БНХАУ-ын Өвөрмонголын их сургуулийн эмнэлгийн хиймэл оюун ухааны оношлогоотой харьцуулан судалсан байна.
4. Төсөл хөтөлбөрийн хүрээнд 3,557.4 мянган төгрөгийн 4 удаагийн сургалт зохион байгуулсан ба үүний үр дүнд хүний нөөцийн ёс зүй харилцаа, хандлагыг дээшлүүлэх, ажлын байрны зохион байгуулалтыг сайжруулах, ажлын байрны осол гэмтэлээс урьдчилан сэргийлэх, амирлуулах тусламжийг хүн бүр хийдэг болох зэрэг сургалтад 110 албан хаагчдыг хамруулсан байна.
5. Хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ, зардал байхгүй.
6. Төрд учирсан хохиролтой холбоотой зардал болон авлага бүртгэгдээгүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 74,591.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 109,000.0

мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 926,628.6 мянган төгрөг, нэр данс зөрүү орлого 20.4 мянган төгрөг, нийт 1,110,240.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 450,462.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 58,093.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 5,725.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 39,850.5 мянган төгрөг, нормативт зардалд 262,624.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 91,255.0 мянган төгрөг, томилолт зочны зардалд 48,289.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 102,100.2 мянган төгрөг, нийт 1,058,401.2 мянган төгрөгийг зарцуулж, 51,526.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрөх он дамжсан 312.2 мянган төгрөгийг замд яваа мөнгө дансанд бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол орны түгээмэл хэрэглэгддэг эмийн ургамалын түүхий эдийн ургахад тохиромжтой бүсчлэл болон тариалалтын судалгаа болон Нойргүйдлийн үед хэрэглэдэг Сүгмэл-3 (Лактука)-ийг практикт нэвтрүүлэх төслүүд 2024-2026 онд хэрэгжихээр судлагдаж байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Уламжлалт анагаах ухааны оношлогооны аргуудад хиймэл оюун ухааны технологийг ашиглах	2023 он - 2025 он	Хиймэл оюун ухааныг уламжлалт анагаах ухаанд ашиглах, оношлогоо хийх	Төслийн хүрээнд 2 үр дүнгийн даалгаврын хүрээнд 350 хүний судалгааг хийж гүйцэтгэж байна.	145,240.0	145,240.0
2	Монгол орны унаган эмийн ургамлуудад өндөр бүтээмжит виртуал скрининг судалгаа хийх, бактер болон мөөгөнцрийн эсрэг үйлдэлтэй эмийн шинэ эх үүсвэрийг эрэлхийлэх	2023 он - 2025 он	Бактер болон мөөгөнцрийн эсрэг үйлдэлтэй эмийн ургамлын виртуал скрининг судалгаа хүний хүрээнд бактер болон мөөгөнцрийн эсрэг үйлдэлтэй эмийн ургамлын хими-фармакологийн судалгаа хийх	49 эмийн ургамлын мэдээллийг 20 үзүүлэлтээр цуглуулсан ба энэ нь давхардсан тоогоор 159 биологийн идэвхт нэгдлийн мэдээлэл агуулсан байна. Энэхүү үзүүлэлтэд өндөр бүтээмжит виртуал скрининг аргаар тооцоолол хийсний үр дүнд 11 нэр төрлийн эмийн ургамалд агуулагдах 29 төрлийн биологийн идэвхт	36,000.0	36,000.0

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

				бодис бичил биетний эсрэг идэвхтэй байж болохыг таамагласан.		
3	Монголын зарим эмийн ургамлын мэдрэлийн доройтол /neurodegenerative/ эмгэгийн эсрэг үзүүлэх нейропроктор нөлөөг in vitro болон in vivo загварууд дээр судлах	2024 он - 2026 он	Шинэ бүтээлийн нэг патент авч, гадаадын сэтгүүлд 2 удаа, дотоодын сэтгүүлд 2удаа эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байна.	Шинэ бүтээлийн патент -1, гадаадын сэтгүүл - 2, дотоодын сэтгүүлд-2 эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн байх ба ҮФӨ-1 боловсруулсан байна.	101,340.0	101,340.0
4	Монгол орны түгээмэл хэрэглэгддэг эмийн ургамалын түүхий эдийн ургахад тохиромжтой бүсчлэл болон тариалалтын судалгаа	2024 он - 2026 он	Монгол хунчир, Сарьлаг хунчир, Урал чихэр өвс, Дэрэвгэр жиргэрүү зэрэг эмийн ургамлын ургахад тохиромжтой бүсчлэлийг тогтоож, олон хувилбарт тарималжуулалтаар агро-арчилгаа, ургалт хөгжлийн онцлог, чанар ба аюулгүй байдлыг судлан, таримал түүхий эдэд суурилсан нэг жорын хими-фармакологийн судалгаа хийгдэнэ.	3 зүйл эмийг ургамлын ургахад тохиромжтой бүсчлэлийн судалгааг хийн Дашинчилэн суманд хээрийн нөхцөлд усалгаатай, хөрс боловсруулсан (W1L1) хувилбараар тариалах нь түүхий эдийн гарцыг нэмэгдүүлэх боломжтойг баталгаажуулан, таримал ургамлын үндсэнд агуулагдах биологийн идэвхи бодисуудыг тодорхойллоо.	80,000.0	50,000.0
5	Нойргүйдлийн үед хэрэглэдэг Сүгмэл-3 (Лактука)-ийг практикт нэвтрүүлэх нь	2024 он - 2026 он	Сүгмэл-3 /Лактука/-ийн хэлбэр өөрчлөх, хими технологи, фармакологийн судалгаа хийх үр дүнд технологийн заавар, ҮФӨ, хэрэглэх заавар боловсруулах ба судалгааны үр дүнгээр эрдэм шинжилгээний дүнгээр өгүүлэл хэвлүүлнэ.	Сүгмэл-3-ийн хэлбэр өөрчлөх судлагаа хийгдсэн бөгөөд эрдэм шинжилгээний өгүүлэл 2 хэвлүүлсэн	50,000.0	47,000.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд 1,764,464.6 мянган төгрөгийн 21 бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөг баталж, гүйцэтгэлээр нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 19 харилцагчтай 809,960.2 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 7 харилцагчтай 184,514.5 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулж, ерөнхий гэрээгээр 9,233.2 мянган төгрөг, үйл ажиллагаатай холбоотой /тогтмол зардал орсон/ 834,229.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийж, нийт 1,837,936.9 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уламжлалт анагаах ухаан, Технологийн хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн хүрээлэн, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мишээл-Од аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор О.Цэндхүү нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 15 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсөв 5,973,999.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 59,740.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага тэвчиж болох зардлуудыг гаргахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлуудыг эрэмбэлэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна. Хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 32 заалтуудыг хамруулан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 320,211.5 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 153 мэдээллээс 151 мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн оруулсан бөгөөд хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 удаагийн 320,211.5 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулж, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, цалин хөлс, татварын бүртгэл, өглөг, авлагын данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 1,176,588.5 мянган төгрөгийн 8 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 8,968.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2,121.8 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 9,652.8 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснөөс тайлант онд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан боловч 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	8,968.0	1	8,968.0	100.0
Албан шаардлага	1	2,121.8	1	2,121.8	100.0
Зөвлөмж	5	9,652.8	4	9,652.8	80.0
Нийт дүн	7	20,742.6	6	20,742.6	85.7

Өмнөх оны аудитаар "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажиллах" зөвлөмж өгсөн боловч тайлант онд төсвийн зарлагыг эдийн засгийн ангилал зөрчиж хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардлаас 15,252.2 мянган төгрөгийн ахуйн цэвэрлэгээний материал, бичиг хэргийн зардлаас 524.8 мянган төгрөгийн тамга цэнэглэх болон албан бланк худалдан авахад, мөн багаж техник хэрэгслийн зардлаас 6,600.0 мянган төгрөгийн агуулахын тавиурыг бэлтгэсэн зөрчил

илэрсэн ба тайлант онд зөрчил давтан гарсан тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус хүрээлэн нь 2024 онд Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засаг хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага болсон тул одоо мөрдөж байгаа Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 онд баталсан НБББББ нь салбарын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна гэж үзэж дараагийн аудитаар анхаарах асуудлаар орууллаа.

Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг сайжруулахтай холбоотой дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт болон Сангийн яамны finperform.mof.gov.mn сайт дахь маягт хоорондын зөрүүг арилгах.
2. Журмын гуравдугаар хавсралтаар батлагдсан дансны жишиг жагсаалтыг дээрх Сангийн яамны шинэ сайттай уялдуулах.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,301.9 мянган төгрөгийн 7 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа: УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга стандартын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой” гэсэн заалтыг хангаагүй дараах алдааг залруулав. Үүнд:

- Завсарын аудитын зөвлөмжөөр илэрсэн музейн өрөөний 9 ширхэг 4,800.0 мянган төгрөгийн өртөг бүхий тавиуруудыг орлогод авч тайлагнаагүй;
- 296.1 мянган төгрөгийн шатахууны зардлыг дотоод албан томилолтын зардалд тайлагнасан;
- 3,300.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтын зардлыг зардлаар хүлээн зөвшөөрөөгүй;
- Аудит баталгаажилтийн төлбөр 3,910.8 мянган төгрөгийг гэрээний дагуу өглөг үүсгэн бүртгээгүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 700.0 мянган төгрөгийн орлогыг 120004, 120010 дансуудад, 295.0 мянган төгрөгийн зардлыг 210801, 210901 дансуудад хооронд нь гүйлгэж тайлагнасан.

Аудитаар нийт 59,046.2 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 5,051.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 35,813.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 18,181.9 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 59,046.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 693.8 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Аудитын түүвэр тооллогоор 4,202.9 мянган төгрөгийн бараа материалын дутагдал илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4-т “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүнээр төлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын түүвэр тооллогоор илэрсэн 4,202.9 мянган төгрөгийн бараа материалын дутагдлыг нөхөн төлүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

Илрүүлэлт 2: Үр дүнгийн урамшууллыг олгохдоо нэг ажилтанд 848.4 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх **төлбөрийн акт** тогтоов.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Өмнөх оны аудитаар “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажиллах” гэсэн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, тайлант онд төсвийн зарлагыг эдийн засгийн ангилал зөрчиж 210405 хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын данснаас 15,252.2 мянган төгрөгийн ахуйн цэвэрлэгээний материал, 210401 бичиг хэргийн зардлаас 524.8 мянган төгрөгийн тамга цэнэглэх болон албан бланк худалдан авч, мөн 210601 багаж техник хэрэгслийн зардлын данснаас 6,600.0 мянган төгрөгийн агуулахын тавиурыг бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-т “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.”, 19.2-т “Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Аудитын түүвэр тооллогоор “Эрдмийн өргөө”-д байрлах үзүүлэнгийн үзмэрүүд нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.1-т “Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана”, 4.1.1-т “Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг холбогдох журмын дагуу үнэлж, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Эрүүл мэндийн даатгалын сангийн “health.gov.mn” програмд өвчтөний бүртгэлийг хариуцлагагүй бүртгэсэн буруутай үйлдлээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээр авах 13,436.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн авах боломжийг алдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д

“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүртгэлд тавих хяналтыг сайжруулж, орлого дутуу төвлөрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эмнэлгийн санхүүжилттэй холбоотой бүртгэлийг Dynamic 1.0 программын Health.dynamic.mn баазаар, эрдэм шинжилгээний төв болон эмийн үйлдвэрийн санхүүжилттэй холбоотой бүртгэлийг Stf.dynamic.mn баазаар бүртгэж байгаагаас шалтгаалан санхүүгийн тайланг эксель тооцооллоор нэгтгэн бэлтгэж, толилуулж байгаа нь тооцооллын алдаа үүсэх эрсдэлтэй, аудитын шалгалтаар журналуудыг нэгтгэн шалгахад хүндрэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т үнэн зөв байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн нэг програмд бүртгэж, санхүүгийн тайлан гаргаж байх

2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус хүрээлэнгийн нэр дээр бүртгэлтэй Гачууртад байрлах сувиллын зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулан авсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т үнэн зөв байх", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших эрхийн гэрчилгээг санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнах

3. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Төлбөрийн цахим баримтад 18 харилцагчийн 10,512.1 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг дутуу, 23 харилцагчид 7.669.8 мянган төгрөгийн төлбөрийн баримт шивээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2-д “хэрэглэгчийн системийн дамжуулсан мэдээллийг үндсэн системийн санд бүрэн, үнэн зөв нэгтгэх, эрх бүхий этгээдэд тайлагнах”, 17.3.1-д “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ”, 17.3.2-д “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.5-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримт олгохоос татгалзах, хуурамч буюу хийгдсэн төлбөр тооцооноос өөр дүнтэй төлбөрийн баримт олгохыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын Төлбөрийн баримт нь бараа,

ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн үйл ажиллагааны орлогын төлбөрийн баримтыг харилцагчдад зөрүүгүй, үнэн зөв олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Завсарын аудитын зөвлөмжөөр илэрсэн музейн өрөөний 9 ширхэг 4,800.0 мянган төгрөгийн өртөг бүхий тавиуруудыг орлогод авч тайлагнаагүй	1	4,800.0			1	4,800.0	1	4,800.0				
2	296.1 мянган төгрөгийн шатахууны зарлагыг дотоод албан томилолтын зардалд тайлагнасан	1	296.1			1	296.1	1	296.1				
3	3,300.0 мянган төгрөгний дотоод албан томилолтын зардлыг зардлаар хүлээн зөвшөөрөөгүй	1	3,300.0			1	3,300.0	1	3,300.0				
4	Аудит баталгаажилтийн төлбөр 3,910.8 мянган төгрөгийг гэрээний дагуу өглөг үүсгэн бүртгээгүй	1	3,910.8	1	3,910.8			1	3,910.8				
5	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 700.0 мянган төгрөгийн орлогыг 120004, 120010 дансуудад, 295.0 мянган төгрөгийн зардлыг 210801, 210901 дансуудад хооронд нь гүйлгэж тайлагнасан.	1	995.0			1	995.0	1	995.0				
	Дүн	5	13,301.9	1	3,910.8	4	9,391.1	5	13,301.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Аудитын түүвэр тооллогоор 4,202.9 мянган төгрөгийн бараа материалын дутагдал илэрсэн.	1	4,202.9	1	4,202.9								
2	Үр дүнгийн урамшууллыг олгохдоо нэг ажилтанд 848.4 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.	1	848.4	1	848.4								
3	Өмнөх оны аудитаар "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажиллах" гэсэн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, тайлант онд төсвийн зарлагыг эдийн засгийн ангилал зөрчиж 210405 хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын данснаас 15,252.2 мянган төгрөгийн ахуйн цэвэрлэгээний материал, 210401 бичиг хэргийн зардлаас 524.8 мянган төгрөгийн тамга цэнэглэх болон албан бланк худалдан авч, мөн 210601 багаж техник хэрэгслийн зардлын данснаас 6,600.0 мянган төгрөгийн агуулахын тавиурыг бэлтгэсэн байна.	1	22,377.0			1	22,377.0						
4	Аудитын түүвэр тооллогоор "Эрдмийн өргөө"-д байрлах үзүүлэнгийн үзмэрүүд нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлгүй байна.	1				1							
5	Эрүүл мэндийн даатгалын сангийн "health.gov.mn" програмд өвчтөний бүртгэлийг хариуцлагагүй бүртгэсэн буруутай үйлдлээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээр авах 13,436.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн авах боломжийг алдсан байна.	1	13,436.0			1	13,436.0						
6	Эмнэлгийн санхүүжилттэй холбоотой бүртгэлийг Dynamic 1.0 программын Health.dynamic.mn баазаар, эрдэм шинжилгээний төв болон эмийн үйлдвэрийн санхүүжилттэй холбоотой бүртгэлийг Stf.dynamic.mn баазаар бүртгэж байгаагаас шалтгаалан санхүүгийн тайланг эксель тооцооллоор нэгтгэн бэлтгэж, толилуулж байгаа нь тооцооллын алдаа үүсэх эрсдэлтэй, аудитын шалгалтаар журналуудыг нэгтгэн шалгахад хүндрэлтэй байна.	1						1					

7	Тус байгууллагын нэр дээр бүртгэлтэй Гачууртад байрлах сувиллын зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг гаргуулан авсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна	1						1		
8	Төлбөрийн цахим баримтад 18 харилцагчийн 10,512.1 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогыг дутуу, 23 харилцагчид 7.669.8 мянган төгрөгийн төлбөрийн баримт шивээгүй байна.	1	18,181.9					1	18,181.9	
Дүн		8	59,046.2	2	5,051.3	3	35,813.0	3	18,181.9	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 удаагийн 320,211.5 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна	1	320,211.5	1	320,211.5					
Нийт дүн		1	320,211.5	1	320,211.5	0	0.0	0	0.0	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 63/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/227/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үр дүнгийн урамшууллыг олгохдоо нэг ажилтанд 848,400.00 /найман зуун дөчин найман мянга дөрвөн зуун/ төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү олгосон 848,400.00 /найман зуун дөчин найман мянга дөрвөн зуун/ төгрөгийг ахлах нягтлан бодогч /Г.Батчимэг/-ээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал /Ч.Чимэдрагчаа/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 64/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/227/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын түүвэр тооллогоор 4,202,900.00 /Дөрвөн сая хоёр зуун хоёр мянга есөн зуун/ төгрөгийн бараа материалын дутагдал илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 4-т "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүнээр төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7-д "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Аудитын түүвэр тооллогоор илэрсэн 4,202,900.00 /Дөрвөн сая хоёр зуун хоёр мянга есөн зуун/ төгрөгийн бараа материалын дутагдлыг ахлах нягтлан бодогч /Г.Батчимэг/-ээр нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал /Ч.Чимэдрагчаа/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 320/А0150061

Улаанбаатар хот

САГ-2026/227/НА - СТА -ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангаж ажиллах" гэсэн зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлээгүй, тайлант онд төсвийн зарлагыг эдийн засгийн ангилал зөрчиж 210405 хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын данснаас 15,252,200.00 /арван таван сая хоёр зуун тавин хоёр мянга хоёр зуун/ төгрөгийн ахуйн цэвэрлэгээний материал, 210401 бичиг хэргийн зардлаас 524,800.00 /таван зуун хорин дөрвөн мянга найман зуун/ төгрөгийн тамга цэнэглэх болон албан бланк худалдан авч, мөн 210601 багаж техник хэрэгслийн зардлын данснаас 6,600,000.00 /зургаан сая зургаан зуун мянган/ төгрөгийн агуулахын тавиурыг бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.", 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилалын дагуу зарцуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал /Ч.Чимэдрагчаа/, ахлах нягтлан бодогч /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 321/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/227/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 27 удаагийн 320,211,484.00 /гурван зуун хорин сая хоёр зуун арван нэгэн мянга дөрвөн зуун наян дөрвөн/ төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал /Ч.Чимэдрагчаа/, ахлах нягтлан бодогч /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 322/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/227/ИА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын түүвэр тооллогоор "Эрдмийн өргөө"-д байрлах үзүүлэнгийн үзмэрүүд нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 4 дүгээр зүйлийн 4.1-т "Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний болон хандив, бэлэглэл, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүжилтийн гүйцэтгэлээр эрх бүхий байгууллагын албан бичиг, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт, хөрөнгө тус бүрийн үнийн задаргааг харгалзан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох журамд заасны дагуу монгол хэлээр, зөв, оновчтой нэршлээр данс бүртгэлд тусгана", 4.1.1-т "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэсэн болон хандив, тусламж, бэлэглэл, төслийн шугамаар бий болсон хөдлөх хөрөнгийг бүртгэлд тусгахад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зөвшөөрөл авах шаардлагагүй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.2-т "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгийг холбогдох журмын дагуу үнэлж, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал /Ч.Чимэдрагчаа/, ахлах нягтлан бодогч /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 323/А0150061

Улаанбаатар хот

САГ - 2026/227/НА-СТА - 7ЦЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн "health.gov.mn" програмд өвчтөний бүртгэлийг хариуцлагагүй бүртгэсэн буруутай үйлдлээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтээр авах 13,436,000.00 /арван гурван сая дөрвөн зуун гучин зургаан мянга/ төгрөгийн орлогыг хүлээн авах боломжийг алдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 "хариуцлагатай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5 "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүртгэлд тавих хяналтыг сайжруулаагүй, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар-сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Захирал /Ч.Чимэдрагчаа/, ахлах нягтлан бодогч /Г.Батчимэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ
Т.ОДОНЧИМЭГ